



ТЭЭВЭР ХӨГЖЛИЙН БАНКНЫ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН Б.ОЮУНЦАЦРАЛ-Н 2024 ОНЫ 2 ДУГААР УЛИРЛЫН АЖЛЫН ТАЙЛАН

2024 оны 7-р сарын 24-ны өдөр

Улаанбаатар хот

Тээвэр Хөгжлийн Банкны Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолоор Б.Оюунцацрал миний бие 2021 оны 04 дүгээр сарын 23-ны өдрөөс тус банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр томилогдон ажиллаж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүний хувьд Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа “Компанийн тухай хууль, Банкны тухай хууль” болон Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батлагдсан “Банкны Зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам”, “Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам”, Тээвэр Хөгжлийн Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам болон Банкны Дүрмийг тус тус мөрдөж хэрэгжүүлэн ажилласан болно.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд оролцсон байдал

Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 2024 оны 06 дугаар сарын 30-ны өдрийг хүртэлх хугацаанд нийт 4 удаа хуралдсан бөгөөд дараах асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэхэд саналын эрхтэй оролцсон болно. Үүнд:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн №Т/24-06 дугаартай хурлаар Тээвэр Хөгжлийн Банкны 2024 оны Тогтворжуулах төлөвлөгөөг хэлэлцэн баталсан бөгөөд зохих саналуудыг хэлж, тус төлөвлөгөөг холбогдох журмын дагуу хугацаанд нь Монголбанканд хүргүүлж ажиллахыг Гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосон.
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн №Т/24-07 дугаартай хурлаар Банкны 2023 оны хөндлөнгийн аудитын байгууллагын тайлан болон удирдлагын захидлын талаар хэлэлцэн тус тайланг удирдлагын захидлын хамтаар Банкны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулахаар шийдвэрлэсэн, ногдол ашиг хуваарилах эсэх тухай асуудлыг хэлэлцэн ногдол ашиг хуваарилахгүй байхаар тогтоож, тус дүгнэлтийг банкны хувьцаа

эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулж шийдвэрлүүлэхээр, банкны 2023 оны үйл ажиллагааны тайлантай танилцаж мөн тус тайланг банкны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулахаар шийдвэрлэж, банкны тогтворжуулах төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулан батлахаар шийдвэрлэн тус төлөвлөгөөг заасан хугацаанд нь Монголбанканд хүргүүлэхийг Гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосон, мөн Монголын ипотекийн корпораци (МИК) хэлцэлд оролцох эрхийг Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгчид олгох тухай тус тус асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэсэн.

3. Төлөөлөн удирдах зөвлийн 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн №Т/24-08 дугаартай хурлаар Банкны хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлах асуудлыг хэлэлцсэн.
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн №Т/24-09 дугаартай хурлаар Банкны “Төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг сайжруулахад чиглэсэн тогтворжуулах 2024 оны төлөвлөгөө”-г хавсралтаар баталж, зохих журмын дагуу заасан хугацаанд Монголбанканд хүргүүлэхийг Гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосон.
5. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн №Т/24-10 дугаартай хурлаар Банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээ /ИСААР/ ба төлбөр түргэн гүйцэтгэх чадварын хүрэлцээ /ЛААР/-н тайлантай танилцаж тус тайланг зохих журмын дагуу заасан хугацаанд Монголбанканд хүргүүлэхийг Гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосон. Мөн тус хурлаар банкны өмчийн эд хөрөнгө худалдан борлуулах тухай асуудлыг хэлэлцүүлж шийдвэрлүүлэхээр банкны хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан төвлөсөн.

Хараат бус гишүүний хувьд дээрх асуудлуудыг дэмжсэн бөгөөд зөрүүтэй байр суурь байгаагүй болно.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх

Аудитын хорооны хуралд оролцсон байдал

1. Миний бие Аудитын хорооны хурлыг Аудитын хорооны даргын хувьд удирдаж явуулсан. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны 2024 оны 04 дүгээр сарын 25-нд хуралдсан бөгөөд тус хурлаар нийт 7 асуудлыг хэлэлцэж, санал дүгнэлт гарган Гүйцэтгэх удирдлагад үүрэг өгч ажилласан бөгөөд тус хурлаар дараахь асуудлуудыг хэлэлцсэн. Үүнд:

- Эрсдэлийн удирдлагын газрын үйл ажиллагаанд хийсэн аудитын тайлан
- Наран салбарын үйл ажиллагаанд хийсэн аудитын тайлан
- Зайсан салбарын үйл ажиллагаанд хийсэн аудитын тайлан
- Зээлийн эрсдэл бодлого зохицуулалтын газрын үйл ажиллагаанд хийсэн аудитын тайлан
- Худалдааны санхүүжилт зээлийн газрын үйл ажиллагаанд хийсэн аудитын тайлан
- Мэдээлэл технологийн газрын харьяа процессингийн хэлтсийн үйл ажиллагаанд хийсэн аудитын тайлан
- Картын удирдлагын хэлтсийн үйл ажиллагаанд хийсэн процессын аудитын тайлантай тус тус танилцаж Гүйцэтгэх удирдлагад дараахь үүрэг даалгаварыг өгч ажилласан. Үүнд:

Эрсдэлийн удирдлагын газрын хүний нөөцийн бүрдэлдэхүүний асуудлыг яаралтай шийдвэрлэхэд анхаарч, мөн хүн олдохгүй тохиолдолд гэрээт ажилтан олох талаас нь ажиллах, гэрээт ажилтан авсан тохиолдолд нууцын гэрээ байгуулан ажиллах талаас анхаарч ажиллахыг банкны хүний нөөцийн газар болон эрсдэлийн удирдлагын газарт;

Банкны хэмжээнд нийт харилцагч байгууллагуудын эцсийн өмчлөгчийн талаарх мэдээллийг өөрчлөгдсөн эсэх тухай мэдээллийг тухайн харилцагчаас улиралд нэг удаа эсхүл хагас жилдээ өөрчлөгдсөн эсэх мэдээллийг зайлшгүй авч байх зохицуулалтыг журамд тусгах зохицуулалтыг хийж гүйцэтгэхийг Салбарын удирдлагын газарт болон харилцагчийн үйлчилгээний газарт;

Зээлдэгч нарт автоматаар даатгалын хугацаа дуусч байгаа тул хугацааг сунгах талаар нэгдсэн байдлаар урьдчилан мэдээлэл очдог байх ажлыг хийж, автоматжуулахыг банкны Худалдааны санхүүжилт, зээлийн газар болон даатгалын зуучлалын хэлтэст тус тус үүрэг болгож ажилласан.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны хуралд оролцсон байдал

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн хурлаар банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээ /ICAAP/ ба төлбөр түргэн гүйцэтгэх чадварын хүрэлцээ /LAAP/-н тайлангийн талаар хэлэлцсэн бөгөөд тус тайланг Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж,

зохих журмын дагуу хугацаанд нь Монголбанканд хүргүүлэхийг банкны
Гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосон.

Хараат бус гишүүний зүгээс дээрх асуудлыг дэмжсэн бөгөөд зөрүүтэй байр суурь
байгаагүй болно.

Тайлан бэлтгэсэн:

ТУЗ-ийн хараат бус гишүүн

A handwritten signature in black ink, consisting of several overlapping loops and a trailing line, positioned between the names of the signatories.

Б.Оюунцацрал